



## Asian Productivity Organization “The APO in the News”

Name of publication: Mongolian Daily News (28 October 2014, Mongolia)

Page: No. 9

### Ногоон Бүтээмжийн Дэлхийн 3 дугаар чуулган Тайпэй хотод болно

2014 оны 11 дүгээр сарын 4-6-ны өдрүүдэд Ногоон бүтээмжийн 70 гаруй бодлого боловсруулагчид, Засгийн газрын байгууллагуудын удирдахалбан тушаалтнууд болон Ногоон бүтээмжийн зөвлөхүүд Тайвань улсын Тайпей хотод чуулах гэж байна. Чуулганыг Азийн Бүтээмжийн Байгууллага, Хятадын Бүтээмжийн Төв хамтран зохион байгуулж байгаа бөгөөд Ази номхон далайн бүс нутгийн 19 орноос төлөөлөгчид уригдсан ба Ерөнхийлөгч Ен-Жү-Ма оролцохоор төлөвлөгдөж байна.

Хүндэт төлөөлөгчид буюу Байгаль орчны сайд асан, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын зөвлөх Доктор Ц.Адъяасүрэн, АНУ-

ын Байгалийн эрчим хүчний хүрээлэнгийн доктор Леон Роуз, Сөүл хот дахь Дэлхийн ногоон өсөлтийн хүрээлэнгийн доктор Жеймс Сүнг Чол Канг нар ногоон хөгжлийн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тухай хэлэлцүүлгийг удирдан явуулах болно.

Хурлын төлөөлөгчид Дэлхийн хамгийн өндөр 101 давхар ногоон байгууламж, Делта электроникс, ДА.АЙ Технологи зэрэг компаниудаар зочилж, туршлага судлах юм.

Энэхүү чуулганы зорилго нь Дэлхийн ногоон хөгжил, ногоон үйлдвэрлэл, экологийн ХАА, нөөцийн дахин боловсруулалт, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах бодлогын баримт бичгийг батлах, Тайпей-с гаргасан

тунхаглалын хэрэгжилтийг хэлэлцэх явдал юм.

Уг чуулганд Монгол Улсын төлөөлөгчдийг хамруулах ажлыг Монголын Бүтээмжийн Төв зохион байгуулан дэмжлэг үзүүлж байгаа бөгөөд манай орноос Стандарт Хэмжил зүйн Үндэсний Төв, Монголын Бүтээмжийн Төв, Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, “Шунхлай” ХХК-иас төлөөлөгчид оролцох юм.

Монгол Улс Азийн Бүтээмжийн Байгууллагын гишүүн бөгөөд Монголын Бүтээмжийн Төв ТББ нь байгууллага, ажахуйн нэгжийн бүтээмжийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх мэргэжлийн сургалт, зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагаа явуулдаг юм.